

ТАНИЛЦУУЛГА

Нотариатч нь төрийн нэрийн өмнөөс хөндлөнгийн гэрчийн үүрэг гүйцэтгэж, үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажилладаг бөгөөд Нотариатын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.3-т “Танхимын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нотариатын үйлчилгээний хөлс болон тээврийн зардлын хэмжээг батална” гэж заасан.

Монголын Нотариатчдын Танхим нь санал гаргахдаа нийт хүн ам, нийгмийн хэрэгцээ, шаардлага, эдийн засгийн нөхцөл байдал, нотариатын үйлдлийн тоо болон нотариатч үйлчилгээний хөлс, орлогоор санхүүжин ажиллах боломж зэргийг харгалзан үздэг бөгөөд дээрх нөхцөл байдал нь нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг нэмэгдүүлэх шаардлагатай болсныг илтгэж байна.

Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 123 тоот тушаалаар батлагдсан “Нотариатын үйлчилгээний хөлс, зардлын хэмжээ”-г баталсан бөгөөд энэхүү жишиг батлагдсанаас хойш манай улсын нийгэм, эдийн засгийн тоон үзүүлэлт өнгөрсөн 11 жилийн хугацаанд улсын хэмжээнд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 3,93 дахин, хүн амын амьжиргааны доод түвшин Хангайн болон Улаанбаатарын бүсчлэлд 168%-иар, хэрэглээний үнийн индекс буюу инфляци 11%, ам.долларын ханш 174.4%-иар өссөн үзүүлэлттэй байна. (Үндэсний статистикийн мэдээллийн нэгдсэн сангийн үзүүлэлт.)

Нотариатч нь төрийн чиг үүргийг хэрэгжүүлдэг нийтийн албан тушаалтан болохын хувьд улсын төсвөөс санхүүжилт, цалин хөлс авахгүйгээр нотариатын үйлчилгээний орлогоосоо Танхим, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн болон эрүүл мэнд, хариуцлагын даатгал, ажлын байрны түрээсийн төлбөр, туслах ажилтны цалин, канон, компьютер, принтер, сканер зэрэг техник хэрэгсэл болон бичиг хэргийн зардлаа хариуцаж, өөрийгөө санхүүжүүлэн ажилладаг. Улс орны эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалан дээрх зардлууд жил ирэх тусам өссөнөөс гадна “цахим нотариат систем” хэрэглэсний төлбөр, дагалдах төхөөрөмж, гарын үсгийн пад, хурууны хээ уншигч, тоон гарын үсгийн гэрчилгээ ашиглах, нотариатын баримт хадгалах зардал улам бүр өсөн нэмэгдэж байна.

Иймд дээрх нөхцөл байдал, судалгааны үр дүн нь нотариатын үйлчилгээний хөлс, зардлыг нэмэгдүүлэх нөхцөл, шаардлагыг тодорхойлж байгаа тул нотариатын үйлдлийн тоо, улс орны эдийн засгийн байдал зэргийг үндэслэж, бодитой тогтоох үүднээс “Тушаалд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” Хууль зүй, дотоод хэргийн сайдын тушаалын төслийг боловсрууллаа.

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМ